



Саналаа Өгөх Сонголтуудын Талаар Судлах



LAVOTE.GOV дээр 6-р сарын 7-нд болох Анхан шатны Сонгуульд хэрэгтэй бүх зүйл бий. The LA County Registrar-Recorder/County Clerk нь сонгуулийн талаарх мэдээлэл бусад холбогдох зүйлсийн үнэн зөв болоод бодит байдлын албан ёсны эх сурвалж юм. Санал өгөх ажиллагаа өмнө нь хэзээ ч ийм хялбар дөхөм, ая тухтай, найдвартай байгаагүй билээ. Сонгуульд та өөрийгөө хэрхэн бэлтгэх талаар дараах зүйлийг уншиж танилцана уу!

Санал өгөхөөр хэрхэн бүртгүүлэх вэ? Бүртгэлийн эцсийн хугацаа хэзээ вэ?

Хэрэв та LA County-д шинээр нүүж ирсэн эсвэл анх удаа саналаа өгөх гэж байгаа бол шуудангаар санал өгөх хуудсаа авахын тулд **2022 оны 5-р сарын 23-ны дотор** бүртгүүлэх ёстой. Санал өгөхөөр бүртгүүлэх хамгийн хялбар арга бол LAVOTE.GOV сайт руу орох юм.

Хэрэв интернет холболт байхгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудсыг номын сан, DMV оффис зэрэг төрийн үйлчилгээний ихэнх байранд очиж авах боломжтой.

Шуудангаар илгээсэн саналаа би өөрөө хянах боломжтой юу?

Боломжтой! Та **"Миний саналын хуудас хаана явна?"** нэртэй дараах сайтад үнэ төлбөргүй бүртгүүлснээр саналын хуудсаа хаана явааг бүрэн хянах боломжтой. (california.ballottrax.net). Танд текст зурвасаар, дуут мессежээр эсвэл цахим шуудангаар таны илгээсэн саналын хуудасны байдлын тухай мэдэгдэл ирэх болно. Мөн Бүртгэлийн газраас таны хуудсыг хүлээн авмагцаа бүртгэн тооцсон тухай мэдэгдэл хүргүүлнэ.

Санал өгөх ямар сонголтууд надад байна вэ?

1. **Шуудангаар саналаа өгөх.** ЛА дүүргээс бүртгэлтэй сонгогч бүрт 6-р сард болох Анхан шатны Сонгуульд оролцох саналын хуудсыг шуудангаар илгээнэ. Саналын хуудсыг 5-р сарын 5-наас явуулж эхэлнэ. Та саналын хуудсыг бөглөж гарын үсгээ зураад дугтуйнд хийж буцаагаад илгээхэд хангалттай. Удаах хэрэггүй. Саналаа эртлэн өгөөрэй!
2. **Саналын Хуудасны Хайрцганд хийх.** 400 Албан ёсны Саналын хуудсаа хийх Хайрцгийн аль нэгэнд нь Саналын Хуудсаа хийснээр та Санал хураах Төв дахь урт дарааллаас зайлсхийх боломжтой. Таны ойролцоох Саналын хуудсаа хийх Хайрцагны байршлын жагсаалтыг шуудангаар илгээх багцад оруулсан байх болно.
3. **Санал авах аль нэгэн төвд 5-р сарын 28-наас эхлэн очих.** Хэрэв та өөрийн биеэр очиж саналаа өгвөл гар утсан дээрх санал асуулгын хуудас ашиглан цагаа хэмнээрэй! Гэрээсээ гарахаасаа өмнө сонголтоо хийх нь Санал өгөх төвд очоод цагаа хэмнэх тохиромжтой арга юм. Бүртгүүлсэн сонгогч бүрт хамгийн ойрын Санал өгөх төвийн байршлыг харуулсан захидал илгээгдэнэ.

Мөн Саналын хуудсаа хийх Хайрцаг болон Санал өгөх Төвийн байршлын бүрэн жагсаалтыг LAVOTE.GOV сайтаас бас авах боломжтой.

ЛА дүүрэгт санал хураалт хэзээ ч ийм амар хялбар байгаагүй.

ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛИЙГ **LAVOTE.GOV** САЙТААР ОРЖ АВНА УУ

